

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2026 ОНЫ НӨХӨН
СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН ТӨСВӨӨС
САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

АУДИТЫН КОД:ХОА-2026/103-ШТА-НА

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.khu@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас:70432545 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Мөнхтулга
Цахим хаяг: munhktulgad@audit.gov.mn
Аудитор: У.Батчимэг
Цахим хаяг: batchimegu@audit.gov.mn

Ховд хот
2026 он

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт	1
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	4
<i>Бүлэг 1: Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуульд улсын төсвөөс олгох санхүүжилтийг аргачлалын дагуу төлөвлөж хуваарилжээ</i>	5
Нөхөн сонгууль зохион байгуулах сонгуулийн хороодын зардлыг хууль, журмын хүрээнд төлөвлөжээ	5
Аймгийн сонгуулийн хороо нь сумдад олгох санхүүжилтийг СЕХ-оос ирсэн аргачлалын дагуу хуваарилжээ	5
<i>Бүлэг 2: Сумын ИТХ-ын нөхөн сонгуулийн зардалд 61.1 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулжээ</i>	6
Аймаг, сумдын сонгуулийн хороо нь батлагдсан төсвийг өр авлага үүсгэхгүйгээр зарцуулжээ	6
Сонгуулийн хороо нь зардлын гүйцэтгэлийг холбогдох журмын дагуу тайлагнажээ	6
Аймгийн сонгуулийн хороо нь сумын сонгуулийн хороодын хөрөнгийн зарцуулалтад хяналт тавин ажиллажээ	7

ТОВЧИЛСОН ҮГ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МТБ	Мэдээлэл технологийн баг
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар

ХҮСНЭГТ

Хүснэгт 1	Сонгуулийн хороодод олгосон санхүүжилт.....	6
Хүснэгт 2	Аймгийн сонгуулийн хорооны нэгтгэсэн тайлан.....	6

Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий Аудиторын “Аудитын сэдэв батлах тухай” 2026 оны А/32 дугаар тушаалыг тус тус үндэслэн “Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл”-д аудит хийнэ.

Аудитын зорилт

Сумын ИТХ-ын 2026 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан Аймгийн ИТХ, Засаг дарга, холбогдох байгууллагуудад танилцуулж, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Аудитын зорилтыг ханган биелүүлэхийн тулд дараах чиглэлээр аудит хийнэ.

- Сумын ИТХ-ын 2026 оны нөхөн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журам, зориулалтын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх
- Сумын ИТХ-ын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх

Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймгийн Сонгуулийн хороо, Мөнххайрхан сумын сонгуулийн хороо, аймгийн Улсын бүртгэлийн газар, Цагдаагийн газар зэрэг байгууллагуудыг хамрууллаа.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам (2020 он), Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал (2020 он)-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Монгол улсын 2026 оны төсвийн тухай хууль:
- Сонгуулийн тухай хууль,
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль,
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль,
- Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан тогтоол, журам,
- Батлагдсан төсөв, төсвийн хуваарь

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Ховд аймгийн хэмжээнд сумдын ИТХ-ын 2026 оны нөхөн сонгууль нь 1 тойрогт зохион байгуулагдсан байна.

Аймгийн сонгуулийн хороонд 7 төрийн албан хаагч, 1 нягтлан бодогч, сумын сонгуулийн хороонд 5, хэсгийн хороонд 7, мэдээлэл технологийн багт 3, улсын бүртгэлийн 1 итгэмжлэгдсэн төлөөлөгч, шуурхай штабын 3, цагдаагийн газраас хамгаалалтад 19 албан хаагч нийт 46 албан хаагч ажиллахаар төлөвлөжээ.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуулийг зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжих зардлыг аймгийн сонгуулийн хорооны 100160022001 тоот дансаар дамжуулан зарцуулсан байна.

Аймгийн сонгуулийн хороонд 46.2 сая төгрөг, Улсын бүртгэлийн хэлтэст 4.6 сая төгрөг, Цагдаагийн газар 10.3 сая нийт 61.1 сая төгрөгийг баталжээ.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу сонгууль зохион байгуулахтай холбогдсон зардлыг дараах байгууллагуудын дансаар дамжин зарцуулагдсан. Үүнд:

- Аймгийн сонгуулийн хороо
- Мөнххайрханы сумын сонгуулийн хороо
- Улсын бүртгэлийн хэлтэс
- Цагдаагийн газар

Орон нутгийн 2026 оны нөхөн сонгуульд 1 хэсэгт 370 сонгогч сонгогчийн нэрсийн жагсаалтад бүртгэгдсэнээс 194 сонгогч санал өгч 52.4 хувийн ирцтэй оролцжээ. Нийт 4 сонгогч зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар саналаа өгөх хуулийн хугацаанд хүсэлтээ өгч 4 иргэн саналаа өгч 100 хувийн ирцтэй байна.

Аймгийн Сонгуулийн хороонд 1 өргөдөл ирснийг хуулийн хугацаанд нэр дэвшигчийг хасах үндэслэлгүй гэсэн хариуг өгсөн байна.

СЕХ-ны 2020 оны 22 дугаар тогтоолоор баталсан “Хяналтын тооллого хийх нийтлэг журам”-ын 2.2-т заасны дагуу 100 хувь хяналтын тооллого хийсэн байна.

Бүлэг 1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд улсын төсвөөс олгох санхүүжилтийг аргачлалын дагуу төлөвлөж хуваарилжээ

Нөхөн сонгууль зохион байгуулах сонгуулийн хороодын зардлыг хууль, журмын хүрээнд төлөвлөжээ

1.1 Ховд аймгийн Сонгуулийн хороог ИТХ-ын даргын 2026 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн А/02 тоот тогтоолоор 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулжээ.

1.2 Мөнххайрхан сумын ИТХ-ын 2026 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 9/03 тоот тогтоолоор 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр, хэсгийн хороог Мөнххайрхан сумын Сонгуулийн хорооны 2026 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн 02 тоот тогтоолоор 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр тус тус байгуулжээ.

1.3 Харьяалагдах нутаг дэвсгэрийн хэмжээнд нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотой аймгийн сонгуулийн хороо 7, сумын сонгуулийн хороонд 5, харьяа хэсгийн хороонд 7, мэдээлэл технологийн багт 2, нягтлан бодогч 1, нийт 23 төрийн албан хаагч ажиллажээ.

1.4 Сумдын ИТХ-ын нөхөн сонгуульд нийт 370 сонгогч бүртгэгдсэнээс 194 сонгогч саналаа өгч 52.4 хувийн ирцтэй оролцжээ.

1.5 СЕХ-оос нутаг дэвсгэрийн хэмжээ, сонгогчийн тоо болон сумын сонгуулийн хороо, тэдгээрт ажиллах гишүүдийн тоо, хэрэгцээ шаардлагыг үндэслэн зардлыг тооцсон байна.

Аймгийн сонгуулийн хороо нь сумдад олгох санхүүжилтийг СЕХ-оос ирсэн аргачлалын дагуу хуваарилжээ

1.6 Сумдын ИТХ-ын нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор СЕХ-оос аймгийн Сонгуулийн хороонд 46.2 сая төгрөгийн санхүүжилтийг хуваарилж гүйцэтгэлээр 46.2 сая төгрөгийн зардал санхүүжүүлсэн байна.

1.7 Сонгууль зохион байгуулахтай холбоотой зардлыг сумдын сонгуулийн хороонд хуваарилахдаа хүн амын тоо, газар нутгийн хэмжээг үндэслэжээ. Аймгийн сонгуулийн хороо нь СЕХ-оос ирүүлсэн зөвлөмжийн дагуу холбогдох зардлуудыг сумын сонгуулийн хороонд хуваарилан ажиллажээ.

1.8 Аймгийн сонгуулийн хороо нь нийт төсвийн 64.1 хувь буюу 29.6 сая, сумдын сонгуулийн хороодод 35.9 хувь буюу 16.6 сая төгрөгийг хуваарилжээ.

1.9 Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст УБЕГ-аас 4.6 сая төгрөгийн санхүүжилт хуваарилж гүйцэтгэлээр 4.6 сая төгрөгийг зарцуулжээ. УБХ-ээс сумдын ИТХ-ын нөхөн сонгуульд 3 төрийн албан хаагч ажиллажээ.

1.10 Аймгийн Цагдаагийн газарт ЦЕГ-аас 10.3 сая төгрөгийн санхүүжилт хуваарилж гүйцэтгэлээр 10.3 сая төгрөгийг зарцуулжээ. Цагдаагийн газрын 19 албан хаагч хамгаалалтад ажилласан байна.

1.11 УБХ болон Цагдаагийн газар нь дээд шатны байгууллагаас ирсэн заавар аргачлалын дагуу төсвийг зарцуулжээ.

Бүлэг 2. Мөнххайрхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуулийн зардалд 61.1 сая төгрөг зарцуулжээ

Аймаг, сумдын сонгуулийн хороо нь батлагдсан төсвийг өр авлага үүсгэхгүйгээр зарцуулжээ

2.1 Аймгийн сонгуулийн хороонд СЕХ-оос ирсэн зөвлөмж, аргачлалын дагуу сумын сонгуулийн хороонд 16.6 сая төгрөгийг аймгийн сонгуулийн хорооноос хуваарилжээ.

2.2 Сумдын сонгуулийн хороо нь аймгийн Сонгуулийн хорооноос өгсөн аргачлал, зөвлөмжийн дагуу зардлыг санхүүжүүлж авлага, өр төлбөр үүсгээгүйгээр ажиллажээ.

Хүснэгт №1: Сонгуулийн хороодод олгосон санхүүжилт

Д/д	Сонгуулийн хорооны нэрс	Төлөвлөгөө /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Зөрүү
1	Аймгийн сонгуулийн хороо	29.6	29.6	0
2	Мөнххайрхан сумын сонгуулийн хороо	16.6	16.6	0
Нийт дүн		46.2	46.2	0

Эх сурвалж. Аймгийн сонгуулийн хорооны санхүүгийн тайлан

2.3 УБЕГ-аас аймгийн УБХ-т 4.6 сая төгрөгийн зардлыг хуваарилж томилолтын зардалд 1.9 сая, тээвэр шатахуунд 1.9 сая, урамшуулалд 0.9 сая, бичиг хэргийн зардалд 0.1 сая төгрөгийг зарцуулжээ.

2.4 Цагдаагийн газарт ЦЕГ-аас 10.3 сая төгрөгийн зардлыг хуваарилж тээвэр шатахуунд 1.7 сая, цагдаагийн албан хаагчийн хоолны зардалд 8.0 сая, томилолтын зардалд 0.6 сая төгрөгийг зарцуулжээ.

Сонгуулийн хороо нь зардлын гүйцэтгэлийг холбогдох журмын дагуу тайлагнажээ

2.6 СЕХ-ны даргын 2025 оны А/33 дугаар захирамжийн 3 дугаар хавсралтаар сумын сонгуулийн хороо нь төсвийн гүйцэтгэлийн тайланг гарган ирүүлж аймгийн сонгуулийн хороо нь нэгтгэн тайлагнасан байна.

Аймгийн сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэлийг харуулбал:

Хүснэгт №2 Аймгийн сонгуулийн хорооны нэгтгэсэн тайлан

№	Зардлын нэр	Батлагдсан төсөв /сая,төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Зөрүү
1	Тогтоол, Протокол, бусад маягт хэвлүүлэх зардал	0.1	0.1	-
2	Хариуцлагатай сонгогч сургалтын зардал	1.3	1.5	(0.2)
3	Бичиг хэргийн зардал	0.5	0.5	-
4	Шуудан холбооны зардал	0.6	0.6	-
5	Унааны зардал	1.5	1.5	-
6	Санал авах байр бэлтгэх зардал	0.3	0.3	-
7	Сурталчилгааны зардал	0.7	0.5	0.2
9	Саналын хуудас, Санал тоолох төхөөрөмж МТБ-аас авах, хүлээлгэн өгөх зардал	9.7	9.7	-
10	МТБагийн мэдээ дамжуулах зардал	0.2	0.2	-

8	Эрчим хүчний эх үүсвэр ашиглах зардал	0.1	0.1	-
11	Томилолтын зардал /дүн тушаах/	4.2	4.2	-
12	Шуурхай багийн зардал	0.9	0.9	-
13	Урамшуулал, хоолны зардал, НДШ	23.0	23.0	-
14	МТБ-ийн гишүүн даамлын урамшуулал, хоолны зардал, НДШ	3.1	3.1	-
	НИЙТ ДҮН	46.2	46.2	-

Эх сурвалж. Аймгийн сонгуулийн хорооны санхүүгийн тайлан

Аймгийн сонгуулийн хороо нь сумын сонгуулийн хорооны зарцуулалтад хяналт тавин ажиллажээ

2.7 Аймгийн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд Мөнххайрхан суманд ажиллаж сонгууль зохион байгуулахтай холбоотой хөрөнгийн зарцуулалт болон санал авах байранд ажиллах сертификат авсан төрийн жинхэнэ албан хаагчдыг хамарсан сургалт, арга зүйн зөвлөмж, зөвлөгөөг өгөн ажилласан байна.

2.8 Аймгийн сонгуулийн хорооны нягтлан бодогч нь сумын сонгуулийн хорооны тайланг хүлээн авахдаа зөрүүтэй илэрхийлсэн алдааг хянаж залруулан авч дүнг үнэн зөв нэгтгэн гаргасан байна.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Сумын ИТХ-ын нөхөн сонгуульд улсын төсвөөс олгох санхүүжилтийг холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж хуваарилжээ.
- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулжээ.

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР